

**“Хутагт Билгийн Чинад Хязгаараа Хүрсэн Очироор Огтлогч” хэмээх их хөлгөн
судар оршвой**

Бурханд мөргөмүй!

Номд мөргөмүй!

Хуврагт мөргөмүй!

Энэтхэгийн хэлээр: *Арьяа Вжрачэдика Нама Пражняпарамита Махаяана Сутра*

Төвдийн хэлээр: *Паг-ва Шэй-рав-жи па-рол-дү чин-ба Дор-жэ жод-ва шэй-жа-ва тэг-чин-бой до шүг-со*

Монголын хэлээр: *Хутагт билгийн чинад хязгаараа хүрсэн очироор огтлогч¹ хэмээх их хөлгөн судар оршвой.*

Хамаг бурхад хийгээд бодьсадва нарт мөргөмүй.

Ийн хэмээн миний сонссон нэгэн цагт Ялж Төгс Нөгцсөн² Бурхан Шравастийн³ Жэта⁴ хан хөвгүүний цэцэрлэг, Анатапиндада⁵ нэрт өглөгийн эзний Хотлыг Баясгах Хүрээнд мянга хоёр зуун тавин аяга тахимлигийн⁶ ихэс хуврагууд хийгээд асар олон бодьсадва⁷, махасадва⁸ нар лугаа хамт нэгнээ ажиран бөлгөө.

Тэндээс Ялж Төгс Нөгцсөн Бурхан бага үдийн үест хормогч хийгээд номт дээлээ өмсөөд бадар аягаа авч Шравасти их хотноо бинваад идээнд⁹ одвой. Тэндээс Ялж Төгс Нөгцсөн Бурхан Шравасти их хотоос бинваад авч ирсэний сүүлээр идээг зооглож, идээний үйлийг зохион¹⁰, цаг бусын идээг¹¹ тэвчиж, бадар аяга хийгээд номт дээлээ талбин хөлөө угаагаад зассан тавцанд биеэн шударга завилж¹² дурьдахуйг илт агуулан суувай. Тэндээс олон аяга тахимлигууд Ялж Төгс Нөгцсөн хаана бүхий тэр зүгт одоод, Ялж Төгс Нөгцсөний өлмийд оройгоороо мөргөж, түүнийг гурвантаа эргэн эргэл үйлдээд хамт нэгнээ суувай.

Бас тэр цагт Амин гавъяат¹³ Субути¹⁴ тэд нөхдийн дунд сууж бөлгөө. Амин гавъяат Субути сууринаасаа босч дээд дээлээ нэгэн мөрөндөө хумиж Ялж Төгс Нөгцсөн хаана бүхий тэр зүгт одоод баруун өвдөгөөрөө сөгдөж алгаан хамтатган ийн хэмээн айлтгавай: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ! Ялж Төгс Нөгцсөн, Түүнчлэн Ирсэн¹⁵, Дайснаа Дарсан¹⁶, Үнэн Төгс Туулсан¹⁷ Бурхан бээр бодьсадва, махасадва нарт туслахын дээд хэдий чинээ тусалсан ба, Түүнчлэн Ирсэн бээр бодьсадва, махасадва нарт огоот¹⁸ хатангидахын¹⁹ дээд хэдий чинээ огоот хатангидсан нь - Ялж Төгс Нөгцсөн минь ээ, гайхамшиг буюу; Сайвар Одсон²⁰ минь ээ,

гайхамшиг буюу. Ялж Төгс Нөгцсөн минь ээ, бодьсадва нарын хөлгөнд үнэхээр²¹ орогсод хэрхэн оршин үйлдмүй, хэрхэн бүтээн үйлдмүй, хэрхэн сэтгэлийг машид барин үйлдмүй?”

Тийн хэмээн өчвөөс Ялж Төгс Нөгцсөн бээр Амин гавъяат Субутид ийн хэмээн зарлиг болвой: “Субути! Сайн, сайн. Субути, тэр түүнчлэн буюу; тэр түүнчлэн буюу. Түүнчлэн Ирсэн бээр бодьсадва, махасадва нарт туслахын дээдээр тусалсан болой. Түүнчлэн Ирсэн бээр бодьсадва, махасадва нарт огоот хатангидахын дээдээр хатангидвай. Субути, тийм учраас, маш сайн сонсоод сэтгэлдээ тогтоогтун! Бодьсадвын хөлгөнд үнэхээр орогсод хэрхэн ямар мэт орших, бүтээх хийгээд сэтгэлийг машид барин үйлдэхийг би чамд номлосугай.”

“Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийн үйлдсүгэй” хэмээн өчөөд Амин гавъяат Субути Ялж Төгс Нөгцсөнийг сонссон лугаа Ялж Төгс Нөгцсөн бээр Амин гавъяат Субутид ийн хэмээн зарлиглавай: “Субути! Үүнд бодьсадвын хөлгөнд орсон [нэгэн] бээр ийн хэмээн, “би бээр хэдий чинээхэн амьтныг амьтанд хураах бээр хураасан - өндөгнөөс төрсөн, умайнаас төрсөн, чийг дулаанаас төрсөн, хувилж төрсөн, дүрст буюу, дүрс үгүйтэн буюу, хуран мэдэхүйтэн (сэрэл хүртэхүйтэн) буюу, хуран мэдэхүй үгүйтэн (сэрэл хүртэхүйгүйтэн) буюу, хуран мэдэхүй үгүй бустан (сэрэл хүртэхүйгүй боловч нарийн хүртэхүйгүй бус) буюу - амьтны язгуур хэдий чинээхэн амьтанд нэрийдэгдсэн бээр шинжилсэн тэдгээр хамаг цогц үлдвэргүйг нирвааны²² төвд паринирваанд²³ оруулсугай. Тэр мэтээр цаглашгүй амьтныг паринирваанд оруулавч амьтан бүр хараахан бас паринирваанд орсонгүй [хэвээр] болой” хэмээн сэтгэл үүсгэгтүн!

“Тэр юуны тул хэмээвээс, Субути, хэрвээ бодьсадва амьтанд хуран мэдэхүй²⁴ (амьтан хэмээн ялгаварлаж үзэхүйд) орох бөгөөс түүнийг “бодьсадва” хэмээн үл нэрийдэхийн тулд болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, амьтанд хуран мэдэхүй орох (амьтан хэмээн ялгаварлан үзэх), аминд хуран мэдэхүй орох (амин хэмээн ялгаварлаж үзэх), бодгалд хуран мэдэхүй орох (бодгал хэмээн ялгаварлан үзэх) бөгөөс түүнийг “бодьсадва” хэмээн үл нэрийдэхийн тулд болой.

“Бас Субути! Бодьсадва эд таваарт үл баримтлан (үл шунан) өглөг өгмүй; алин юуг ч бас үл баримтлан (үл горилон) өглөг өгмүй. Дүрсэд үл баримтлан (үл шунан) өглөг өгмүй. Түүнчлэн дуу, үнэр, амт, хүрэлцэхүй хийгээд номонд ч бас үл баримтлан (юмсад ч бас үл шунан) өглөг өгмүй. Субути, юуг боловч бэлгэ чанарт хэмээн хуран мэдэхүй орохүйд үл баримтлан (аливааг бэлгэ чанараар нь ялгаварлан үл баримталж) тэр мэт бодьсадва өглөг өгмүй. Тэр юуны тул хэмээвээс, Субути, юунд ч үл баримтлан (үл шунан) өглөг өгөх бодьсадвын буяны цогц нь, Субути, хэмжихүйеэ хялбар бусын тулд болой.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Дорно зүгийн огторгуйг хэмжихүйеэ хялбар болов уу?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой.”

Ялж Төгс нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, түүнчлэн өмнө, өрнө, умар, дээр, доор, зүг зовхис хийгээд арван зүгийн огторгуйг хэмжихүйеэ хялбар болмуй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, түүнчлэн алин юунд ч баримтлах үгүйеэ өглөг өгөгч бодьсадвын буяны цогц нь, Субути, хэмжихүйеэ хялбар бусын тулд болой.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Лагшин бэлгэ хотол төгссөнийг²⁵ Түүнчлэн Ирсэн хэмээн үзмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой. Лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн ирсэнд үл үзэх бөлгөө. Тэр юуны тул хэмээвээс, Түүнчлэн Ирсэн бээр лагшин бэлгэ хотол төгссөн хэмээн алин номлосон тэр ямагт²⁶ лагшин бэлгэ хотол төгссөн бусын тулд болой.”

Тийн хэмээн өчвөөс, Ялж Төгс Нөгцсөн бээр Амин гавъяат Субутид ийн хэмээн зарлиг болвой: “Субути, хэдий чинээ лагшин бэлгэ хотол төгссөн төдий чинээгээр хуурмаг болой. Хэдий чинээ лагшин бэлэг хотол төгссөн үгүй хэмээнэ төдий чинээ хуурмаг бус болой. Тэр мэт Түүнчлэн Ирсэнийг лагшин хийгээд бэлгэ үгүйд үзэгтүн!”

Тийн хэмээн зарлиг болсон лугаа Амин гавъяат Субути бээр Ялж Төгс Нөгцсөнд ийн хэмээн өчвэй: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, ирээдүйн таван зууны²⁷ эцэст дээдийн ном машид тийн эвдрэхүйд ариун энэ үзлийн судрын аймгийн үсгийг үзүүлсэн эдгээр номлолд үнэхээр хураан мэдэхүй төрүүлэгч ямар нэгэн төрөлхтөн гарах болов уу?”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, чи ийн хэмээн, “ирээдүйн таван зууны эцэст дээдийн ном машид тийн эвдрэхүйд ариун энэ үзлийн судрын аймгийн үсгийг үзүүлсэн эдгээр номлолд үнэхээр хураан мэдэхүй төрүүлэгч ямар нэгэн төрөлхтөн гарах болов уу” хэмээн бүү өгүүлэгтүн! Субути, ирээдүйн таван зууны эцэст дээдийн ном машид тийн эвдрэхүйд шагшаабад лугаа төгөлдөр, эрдэм увдис лугаа төгссөн бодьсадва, махасадва нар төрмүй. Субути, тэдгээр бодьсадва, махасадва нар нь нэгэн бурханд өргөл хүндлэл үйлдэх бус; нэгэн бурханд буяны үндсийг үүсгэх бус аа. Субути, түмэн олон бурхадад өргөл хүндлэл үйлдсэн бөгөөд түг түмэн бурхадад буяны үндсийг үүсгэсэн бодьсадва, махасадва нар төрмүй.

“Субути, хэн бээр тэр мэт судрын аймгийн үсгийг номлосон буянд нэгэн сэтгэлийн төдийхөн сүжгийг олсон тэдгээрийг Түүнчлэн Ирсэн бээр мэдмүй. Субути, тэдгээрийг Түүнчлэн Ирсэн бээр үзэх болой; Субути, хамаг тэдгээр амьтад нь буяны цогц цаглашгүйг үүсгэх бөгөөд огоот хураах болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, тэдгээр бодьсадва, махасадва нар нь би хэмээхэд хуран мэдэхүй орохуй үгүй (би-д ялгаварлан барихгүй) бөгөөд амьтанд хуран мэдэхүй орохуй үгүй (нэг ч амьтныг ялгаварлан үзэхгүй), аминд хуран

мэдэхүй орохуй үгүй (амин хэмээн ялгаварлан үзэхгүй), бодгалд хуран мэдэхүй орохуй үгүйн (нэг ч бодгалыг ялгаварлан үзэхгүйн) тулд болой.

Субути, тэдгээр бодьсадва, махасадва нар нь номд хуран мэдэхүй (нэг ч номыг буюу юм үзэгдлийг ялгаварлан үзэхгүй) хийгээд ном үгүйд ч бас хуран мэдэхүй үл орох (номгүйд ч буюу юм үзэгдэл бусыг ч бас ялгаварлан үзэхгүй) болой. Тэдгээр нь хуран мэдэхүй хийгээд хуран мэдэхүй үгүйд ч (ялгаварлан үзэх хийгээд эс ялгаварлан үзэхүйд ч) бас орохуй үгүй болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, хэрвээ тэдгээр бодьсадва, махасадва нар нь номд хуран мэдэхүй орох (нэг боловч юм үзэгдлийг ялгаварлан үзэх) болвоос, бас мөнхүү тэдгээр бээр би хэмээн баримтлах болоод, амьтанд баримтлах, аминд баримтлах, бодгалд баримтлах болохын тулд болой. Хэрвээ номыг би үгүйд хураан мэдэхүй (юм үзэгдлийг эс оршихуйд ялгаварлан үзвээс) орвоос бас мөнхүү тэдгээр бээр би хэмээн баримтлах болоод, амьтанд баримтлах, аминд баримтлах, бодгалд баримтлах болохын тулд болой.

“Тэр юуны тул хэмээвээс, Субути, бодьсадва номыг ч бурууд үл барих (юм үзэгдлийг буруу танин мэдэхгүй), ном бусыг ч бас бурууд үл барихын (юм үзэгдэл бусыг ч буруу танин мэдэхгүйн) тулд болой.”

Тиймийн тулд, Түүнчлэн Ирсэн бээр номын энэ зүйлийг сал онгоц²⁸ мэт мэдэгч нар хамаг номыг ч тэвчин үйлдэх тул, хамаг ном бусыг өгүүлэх хэрэг юун билээ хэмээн номловой.”

Бас Ялж Төгс Нөгцсөн бээр Амин гавъяат Субутид ийн хэмээн зарлиг болвой: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэн бээр аль дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт Илтэд Туулсан Бурхан болсон ном аль буй хэмээн сэтгэмүй?”

Тийн хэмээн зарлигласан лугаа Амин гавъяат Субути бээр Ялж Төгс Нөгцсөнд ийн хэмээн өчвэй: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, би бээр Ялж Төгс Нөгцсөний номлосон утгыг ухах мэт болвоос Түүнчлэн Ирсэн бээр аль дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт Илтэд Туулсан Бурхан болсон тэр ном алин бээр үгүй бөлгөө. Түүнчлэн Ирсэний үзүүлсэн тэр ном алин бээр үгүй бөлгөө. Тэр юуны тул хэмээвээс, Түүнчлэн Ирсэн аль номоор илтэд туулсан бурхан болсон ба, үзүүлсэн түүнийг барин тогтоох үгүй, өгүүлэх үгүй болой. Тэр нь ном ч бус, ном бус ч бусын тулд болой. Тэр юуны тул хэмээвээс, Хутагтын төрөлхийтөн нар хуран эс үүдсэнээр машид ялгасны тулд болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Язгууртаны хөвгүүн, язгууртаны охин²⁹ алин зарим нэгэн бээр гурван мянган их мянган ертөнцийн³⁰ энэ орныг элдэв долоон их эрдэнэсээр сайтар дүүргээд өглөг өгвөөс тэдгээр язгууртаны хөвгүүд, язгууртаны охид тэр шүтээнээс буяны цогц олныг үүсгэх болмуй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, олон болой. Сайвар Одсон минь ээ, их олон болой. Тэр юуны тул хэмээвээс, буяны цогц тэр ямагт цогц үгүйн тулд болой; тиймийн тулд, Түүнчлэн Ирсэн бээр “буяны цогц, буяны цогц” хэмээн номлосон болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, язгууртаны хөвгүүн, язгууртаны охин хэн бээр гурван мянган их мянган ертөнцийн тэр орныг элдэв долоон их эрдэнэсээр сайтар дүүргээд өглөг өгсөнөөс, хэн бээр номын энэ зүйлээс адаглаад дөрвөн мөрт шүлгийн төдийхнийг тогтоож бусдад номлох бөгөөд үнэхээр сайтар үзүүлвээс тэр шүтээнээс үүсэх буяны цогц нэн олон, тоо томшгүй хийгээд цаглашгүй бөлгөө. Тэр юуны тул хэмээвээс, Субути, Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхадын дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутаг түүнээс гараад, Ялж Төгс Нөгцсөн Бурхад ч бас түүнээс төрсөний тулд болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, бурханы ном, бурханы ном хэмээгдэх нь тэдгээр бурханы ном үгүй хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тулд, тэдгээр нь “бурханы ном” хэмээгдьюү.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Үргэлжид орсон [нэгэн] бээр ийн хэмээн, “би бээр үргэлжид орсоны үрийг оллоо” хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр юунд ч орсон бусын тулд болой; тиймийн тулд, “үргэлжид орсон” хэмээгдьюү. Дүрсэд ч орсон бус, дуунд ч бус, үнэрт ч бус, амтанд ч бус, хүрэлцэхүйд ч бус, ном дор ч орсон бус болой; тиймийн тулд, “үргэлжид орсон” хэмээгдьюү. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, хэрвээ үргэлжид орсон [нэгэн] бээр ийн хэмээн, “би бээр үргэлжид орсоны үрийг оллоо” хэмээн сэтгэх бөгөөс тэр ямагт нь би хэмээх баримтлал болмуй. Амьтанд баримтлахуй, аминд баримтлахуй хийгээд бодгалд баримтлахуй болмуй.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Нэгэнт харин ирэгч ийн хэмээн, “би бээр нэгэнт харин ирсэний үрийг оллоо” хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой. Тэр юуны тул хэмээвээс, тэрхүү харин ирсэний хутгийг олсоны тэр ном алин бээр үгүйн тулд болой; тиймийн тулд, “нэгэнт харин ирсэн” хэмээгдьюү. Ялж Төгс Нөгцсөн минь ээ, хэрвээ нэгэнт харин ирсэн ийн хэмээн, “би бээр нэгэнт харин ирсэний үрийг оллоо” хэмээн сэтгэх болвоос, мөнхүү тэрээр би хэмээн баримтлах болмой. Амьтанд баримтлах хийгээд бодгалд баримтлах болмой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Харин үл ирэгч ийн хэмээн, “би бээр харин үл ирсэний үрийг оллоо” хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой. Тэр юуны тул хэмээвээс, тэрхүү харин үл ирсэний хутгийг олсоны тэр ном алин бээр үгүйн тулд болой; тиймийн тулд, “харин үл ирсэн” хэмээгдьюу.

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Дайснаа Дарсан [архад] ийн хэмээн, “би бээр Дайснаа Дарсан [архадын] хутгийг оллоо” хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой. Тэр юуны тул хэмээвээс, аливаа Дайснаа Дарсан хэмээгдэхүйн тэр ном алин бээр үгүйн тулд болой. Ялж Төгс Нөгцсөн минь ээ, хэрвээ Дайснаа Дарсан [архад] ийн хэмээн, “би бээр Дайснаа Дарсан [архадын] хутгийг оллоо” хэмээн сэтгэх болвоос, тэр ямагт тэрээр би хэмээн баримтлах болмуй. Амьтанд баримтлах, аминд баримтлах хийгээд бодгалд баримтлах болмой.

“Ялж Төгс Нөгцсөн минь ээ, Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхан бээр намайг нисваанис³¹ үгүй оршигсдын манлайн дээд хэмээн үзүүлсэн болой. Ялж Төгс Нөгцсөн минь ээ, би шунал тачаал лугаа хагацсан Дайснаа Дарсан Архад мөн боловч; Ялж Төгс Нөгцсөн минь ээ, би ийн хэмээн, “би болвоос Дайснаа Дарсан болой” хэмээн үл сэтгэмүй. Ялж Төгс нөгцсөн минь ээ, хэрвээ ийн хэмээн, “би бээр Дайснаа Дарсан Архадын хутгийг оллоо” хэмээн сэтгэх бөгөөс, Түүнчлэн Ирсэн бээр намайг “язгууртаны хөвгүүн Субути болвоос нисваанис үгүй оршигсодын манлайн дээд мөн бөгөөд юунд ч эс оршсон нь нисваанис үгүй оршсон” хэмээн бивангирд³² эс үзүүлэх болмуй.”

Ялж Төгс нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэний Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхан Дипанкараас³³ авсан тэр ном аль буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс нөгцсөн минь ээ, тийм бус болой. Түүнчлэн Ирсэний Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан бурхан Дипанкараас авсан тэр ном алин бээр үгүй болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, бодьсадва алин зарим ийн хэмээн, “би бээр байгуулсан хамаг орныг чухамтай бүтээлээ” хэмээх бөгөөс тэр нь үнэнээр өгүүлсэн бус хэрэг болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, байгуулсан орныг “байгуулсан орон” хэмээх нь, байгуулсан тэдгээрийг буй бус хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “байгуулсан орон” хэмээгдьюу. Субути, тэр мэтийн тул, бодьсадва, махасадва нар энэ мэт үл оршсон бээр сэтгэл үүсгээд, юунд ч эс оршсон бээр сэтгэл үүсгэмүй. Дүрсэд эс орших бээр сэтгэл үүсгэмүй. Дуу, үнэр, амт, хүрэлцэхүй хийгээд ном дор ч эс оршсон бээр сэтгэл үүсгэмүй.

“Субути, энэ мэт бөгөөд үлгэрлэвээс, нэгэн төрөлхийтний бие энэ мэтэд урваад, энэ мэт нь ч уулсын хаан Сүмбэр уулын төдий болвоос, Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Тэр биеийг их мөн хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр бие их бөлгөө. Сайвар Одсон минь ээ, тэр бие их нэгэн бөлгөө. Тэр юуны тул хэмээвээс, Түүнчлэн Ирсэн бээр тэр бодтой бус хэмээн номлосны тулд болой; тиймийн тулд, тэр бээр “их бие” хэмээгдьюю.

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Ганга мөрний элс хэдий чинээ буй Ганга мөрөн ч төдий чинээ тоот болж гэмээ нь тэдгээрийн элс алин буй тэдгээрийг олон буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэдгээр Ганга мөрөн бас олон бөгөөтөл тэдгээрийн элсийг өгүүлэх юун билээ.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, чи бишрэгтүн! Чи бээр сайтар ухаж мэдтүгэй! Тэдгээр Ганга мөрний элс хэдий чинээ, төдий чинээ тоот ертөнцийн орныг зарим нэгэн эрэгтэй, эмэгтэй бээр элдэв долоон их эрдэнэсээр сайтар дүүргээд, Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхдад өглөг өргөвөөс, Субути үүнийг юун хэмээн сэтгэмүй? Тэдгээр эрэгтэй, эмэгтэй тэр шүтээнээс их олон буяныг үүсгэх болмуу?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, их олон болой. Сайвар Одсон минь ээ, их олон болой. Тэдгээр эрэгтэй, эмэгтэй тэр шүтээнээс буян их олныг үүсгэх бөлгөө.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, хэн бээр ертөнцийн орныг мөнхүү элдэв долоон их эрдэнэсээр сайтар дүүргээд Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхдад өглөг өргөснөөс, хэн бээр номын энэ зүйлээс адаглаад дөрвөн мөрт шүлгийн төдийг тогтоож бусдад сайтар номлоод, үнэхээр сайтар үзүүлсэн тэр ямагт шүтээнээс буян нэн их олон, тоолшгүй бөгөөд цаглашгүй үүсэх бөлгөө.

“Бас бээр Субути, чухам аль зүгт номын энэ зүйлээс адаглаад дөрвөн мөрт шүлгийн төдийг унших бөгөөд номлон үзүүлсэн тэр зүг тэнгэр хийгээд хүмүүн, асура сэлтийн ертөнцийн тахил шүтээний [ариун орон] болох бөгөөтөл, хэн бээр энэ номын зүйлийг авсан, бичсэн, тогтоосон, хадгалсан, уншсан, бүхнийг агуулан үйлдсэн хийгээд сэтгэлдээ ёсчлон үйлдсэн тэр нь маш гайхамшиг хийгээд төгөлдөр болохыг өгүүлэх юун бөгөөд, бас тэр газар, зүгт ном үзүүлэгч [заларч]; [бусад] лам багш нар бээр ч [хамт] нэгнээ оршмой.”

Тийн хэмээн зарлиглаваас, Амин гавъяат Субути, Ялж Төгс Нөгцсөнд ийн хэмээн өчвэй: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр номын зүйлийн нэр юу буй? Түүнийг хэрхэн тогтоомуй?”

Тийн хэмээн өчсөн лүгээ Ялж Төгс Нөгцсөн бээр Амин гавъяат Субутид ийн хэмээн зарлиг болвой: “Субути, энэ номын зүйлийн нэр нь “Билиг барамид”³⁴ хэмээгдэх бөгөөд үүнийг тэр мэт тогтоогтүн! Тэр юуны тул хэмээвээс, Субути, Түүнчлэн Ирсэн бээр “билиг

барамид” хэмээн алин тэр номлосон нь билиг барамид бусын тулд болой; тиймийн тул, “билиг барамид” хэмээгдьюү.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэний номлосон тэр ном аль буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, Түүнчлэн Ирсэний номлосон тэр ном алин бээр эс орших болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Гурван мянган их мянган ертөнцийн орон газрын шорооны тоос хэдий чинээ буй тэр олон буюу хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр шорооны тоос олон болой. Сайвар Одсон минь ээ, олон болой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, шорооны тоос алин буй тэр тоос буй бус хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “шорооны тоос” хэмээгдьюү. Ертөнцийн орон алин буй тэдгээр орон буй бус хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “ертөнцийн орон” хэмээгдьюү.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Их төрөлхийтний гучин хоёр лагшин бэлгээр Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурханд үзэгдэх хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой. Тэр юуны тул хэмээвээс, Түүнчлэн Ирсэний номлосон их төрөлхийтний тэдгээр гучин хоёр лагшин бэлгийг лагшин бэлгэ бус хэмээн Түүнчлэн ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, их төрөлхийтний “гучин хоёр лагшин бэлгэ” хэмээгдьюү.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, эрэгтэй, эмэгтэй алин зарим бээр биеэ Ганга мөрний элс хэдийчинээ, төдий тоогоор огоот өгсөнөөс, хэн бээр номын энэ зүйлээс адаглаад дөрвөн мөрт шүлгийн төдийг тогтоож, бусдад үнэхээр номлон үзүүлсэн тэр ямагт шүтээнээс их олон буян, тоо томшгүй хийгээд цаглашгүй үүсэх болой.”

Тэндээс Амин гавъяат Субути эл номын хүчээр нулимс унаган, урсах нулимсаа арчаад Ялж Төгс Нөгцсөнд ийн хэмээн өчвэй: “Энэ номын зүйлийг Түүнчлэн Ирсэн бээр хэдий чинээ номлосон нь, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, гайхамшиг болой. Сайвар Одсон минь ээ, гайхамшиг болой. Ялж Төгс Нөгцсөн минь ээ, эш ухааныг олсоноос хойш би бээр номын энэ зүйлийг урьд хэзээ ч сонссонгүй болой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, энэ судрын аймгийн номлолд үнэхээр хуран мэдэхүй төрүүлэх тэдгээр амьтад нь хэн боловч машид гайхамшиг лугаа төгсөх болой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, үнэхээр хуран мэдэхүй алин буй тэр ямагт хуран мэдэхүй үгүйн тулд болой; тиймийн тул, “үнэхээр хуран мэдэхүй” хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосон болой. Ялж Төгс Нөгцсөн

минь ээ, би энэ номын зүйлийг номлосон дор шинжлэх бөгөөд дурших нь надад гайхамшиг бус болой. Ялж Төгс Нөгцсөн минь ээ, хойдын үес, хойдын цаг таван зууны эцэст энэ номын зүйлийг авах, бичих, хадгалах, тогтоох, унших хийгээд, бүхнийг агуулан үйлдэх алимад тэдгээр амьтад машид гайхамшиг лугаа төгсөх болой. Бас Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэдгээр нь би хэмээхэд хуран мэдэхүй үл орох бөгөөд, амьтанд хуран мэдэхүй, аминд хуран мэдэхүй, бодгалд хуран мэдэхүй орохуй үгүй болмой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, би хэмээхэд хуран мэдэхүй, амьтанд хуран мэдэхүй, аминд хуран мэдэхүй, бодгалд хуран мэдэхүй алин буй тэр ямагт хуран мэдэхүй бүхэн лүгээ хагацсаны тулд болой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн Бурхад нь хамаг хуран мэдэхүй лүгээ хагацсаны тулд болой.”

Тийн хэмээн өчвөөс, Ялж Төгс Нөгцсөн бээр Амин гавъяат Субутид ийн хэмээн зарлиг болвой: “Субути, тэр түүнчлэн болой; тэр түүнчлэн болой. Судрын аймгийн энэ номыг үзүүлэхүй дор үл айх бөгөөд, цочих бүхэнд үл автсан алимад тэдгээр амьтад машид гайхамшиг лугаа төгсөх болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, энэхүү дээд “Билиг барамид”-ыг Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой. Түүнчлэн Ирсэний номлосон энэхүү дээд “Билиг барамид”-ыг цаглашгүй бөгөөд хэмжээлшгүй Ялж Төгс Нөгцсөн Бурхад ч бас номлосны тулд болой; тиймийн тул, “дээд билиг барамид” хэмээгдью.

“Бас Субути, Түүнчлэн Ирсэний хүлцэнгүйн барамид аль буй тэр ямагт барамид бус болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, аль цагт Калинга³⁵ [улсын] хаан миний үе мөч хийгээд гишүүн бүхнийг огтолсон тэр цагт надад би хэмээхэд хуран мэдэж сэтгэхүй, амьтанд хуран мэдэж сэтгэхүй, аминд хуран мэдэж сэтгэхүй, бодгалд хуран мэдэж сэтгэхүй ч бас эс төрсөн бөгөөд, надад хуран мэдэхүй юухан ч үгүйн сацуу хуран мэдэхүй үгүй бээр болсон нь бас [хараахан] бусын тулд болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, хэрвээ тэр цагт би хэмээхэд хуран мэдэхүй төрсөн болвоос, тэр цагт хорт сэтгэлийн хуран мэдэхүй ч бас төрж; амьтанд хуран мэдэхүй, аминд хуран мэдэхүй, бодгалд хуран мэдэхүй төрж, тэр цагт хорт сэтгэлийн хуран мэдэхүй ч бас төрөхийн тулд болой.

“Субути, би бээр илтэд мэдэн ухваас, өнгөрсөн цагт миний [эдүгээгээс урагш] таван зуу дахь төрөл “Хүлцэнгүйн Өгүүлэгч” хэмээгдэгч арш болон төрсөн тэр цагт ч надад би хэмээх хуран мэдэхүй эс төрсөн; амьтанд хуран мэдэхүй, аминд хуран мэдэхүй хийгээд бодгалд хуран мэдэхүй ч эс төрсөн билээ. Субути, тэр мэтийн тул, бодьсадва, махасадва нар хамаг хуран мэдэхүйг сайтар тэвчээд, дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт сэтгэл үүсгэмүй. Дүрсэд үл орших сэтгэл үүсгэмүй. Дуу, үнэр, амт хийгээд хүрэлцэхүйд ч эс орших сэтгэл үүсгэмүй. Ном дор ч эс орших сэтгэл үүсгэмүй. Ном үгүйд ч бас эс орших сэтгэл үүсгэмүй. Юуханд боловч бас эс орших сэтгэл үүсгэмүй. Тэр юуны тул хэмээвээс, алин тэр

оршихуй тэр ямагт эс оршихын тулд болой. Тиймийн тул, Түүнчлэн Ирсэн бээр ийн хэмээн, “бодьсадва юунд ч эс оршин өглөг өгмүй” хэмээн номловой.

“Бас Субути, бодьсадва энэ мэт хамаг амьтны тусын тулд өглөгийг огоот өгмүй. Амьтанд хуран мэдэгч аль буй тэр ямагт ч бас хуран мэдэхүй үгүй бөгөөд Түүнчлэн Ирсэн бээр “хамаг амьтан” хэмээн алимад номлосон тэдгээр амьтан нь ч бас эс орших буюу. Тэр юуны тул хэмээвээс, Субути, Түүнчлэн Ирсэн нь үнэхээр номлосон³⁶, үнэнээр номлосон³⁷, түүнчлэнхүү чанарт номлосон бөгөөд Түүнчлэн Ирсэн нь [алжаас] бурууд номлосон бусын тулд болой.

“Бас Субути, Түүнчлэн Ирсэний ном алин бас Илтэд Туулсан Бурханы үзүүлсэн тэр номд үнэн ч үгүй, хуурмаг ч үгүй болой. Субути, тэр мэт бөгөөд үлгэрлэвээс: нүдэн төгөлдөр нэгэн хүмүүн харанхуйд орвоос юухан ч эс үзэх адил аливаа бодод унасан бээр өглөг огоот өгөхүйн бодьсадва үзэгдьюү.

“Бас Субути, тэр мэт бөгөөд үлгэрлэвээс, үүр гийж наран ургаваас нүдэн төгөлдөр хүмүүн элдэв өнгө дүрс, дүр байдлыг үзэх адил аливаа бодод эс унасан бээр өглөгийг огоот өгөхүйн бодьсадва үзэгдьюү.

“Бас Субути, язгууртаны хөвгүүн, язгууртаны охин хэн бээр номын энэ зүйлийг авсан, барьсан, тогтоосон, уншсан, бүхнийг агуулан үйлдсэн хийгээд бусдад аугаа ихэд үнэхээр сайтар номлон үзүүлсэн тэдгээрийг Түүнчлэн Ирсэн бээр мэдэх болой, Түүнчлэн Ирсэн бээр үзэх болой. Тэдгээр амьтан цаглашгүй буяны цогцыг үүсгэх больюү.

“Бас Субути, аливаа зарим нэгэн эрэгтэй, эмэгтэй эрт үдийн цагийн үест биесийг Ганга мөрний элсний тоогоор огоот өгөх - бас үдийн цаг хийгээд үдэш оройн цагийн үест биесээ Ганга мөрний элсний чинээгээр огоот өгөх бөгөөд энэ зүйл тоо мэтээр олон буман голди³⁸ хийгээд наяд³⁹ галвуудад⁴⁰ биесээ огоот өгсөнөөс - хэн бээр номын энэ зүйлийг сонсоод үл тэвчсэн тэр шүтээнээс буян асар илүү олонд, тоо томшгүй, цаглашгүй үүсэх бөгөөтөл, хэн бээр үсгийг бичих, авах, барих, тогтоох, унших, бүхнийг агуулан үйлдэх⁴¹ хийгээд бусдад аугаа ихэд үнэхээр сайтар номлон үзүүлэхийг өгүүлэх юун билээ.

“Бас Субути, номын энэ зүйл нь санаж сэтгэшгүй бөгөөд тэнцэшгүй бөлгөө. Энэ номын зүйлийн ач үрс ч бас санаж сэтгэшгүй чанарт хэмээн мэдэгтүн! Энэ номын зүйлийг дээд хөлгөнд үнэхээр орсон амьтан бүхний тус хийгээд үлэмж хэтэрхийд хүрсэн хөлгөнд үнэхээр орсон амьтан бүхний тусын тулд Түүнчлэн Ирсэн бээр номловой. Хэн бээр энэ номын зүйлийг авсан, барьсан, тогтоосон, уншсан, бүхнийг агуулан үйлдсэн хийгээд бусдад аугаа ихэд үнэхээр сайтар номлон үзүүлсэн тэдгээрийг Түүнчлэн Ирсэн бээр мэдэх болой; Түүнчлэн Ирсэн бээр үзэх болой. Тэдгээр амьтан бүхний буяны цогц цаглашгүй лугаа төгөлдөр болмой. Тэр буяны цогц санаж сэтгэшгүй, сацлашгүй, үлшгүй хийгээд хэмжээгүй лүгээ төгөлдөр болмой. Тэдгээр амьтан бүхэн миний бодийн хутгийг мөрөндөө өргөх болмой.

Тэр юуны тул хэмээвээс, Субути, доордод дуршигчид бээр энэ номын зүйлийг сонсож үл чадьюу. Би хэмээхэд үзэгсэд бус, амьтанд үзэгсэд бус, аминд үзэгсэд бус бөгөөд бодгалд үзэгсэд бээр сонсож, авч, хадгалж, уншиж хийгээд бүхнийг агуулан үйлдэж үл чадах болой. Тэр нь ёс үгүйн тулд болой.

“Бас Субути, аль газар зүгт энэ судрын аймгийг номлон үзүүлнэ, тэр газар зүгт тэнгэр, хүмүүн хийгээд асура сэлтийн ертөнц дахины тахилын үйлд зохист болмой. Тэр газар зүг мөргөлийн үйлд зохист хийгээд эргэлийн үйлд зохист болмой. Тэр газар зүг тахил шүтээн мэт болмой.

“Бас Субути, язгууртаны хөвгүүн, язгууртаны охин хэн бээр энэ мэт судрын аймгийн үг үсгийг авах, барих, тогтоох, унших хийгээд бүхнийг агуулан үйлдэнэ, тэдгээр нь энэлэх болмой. Машид энэлэх болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, тэдгээр амьтад өөрсдийн урьдын төрлүүдэд үйлдсэн муу заяанд төрөхүйн уг болсон буян бусын үйлийн үрээр энэ төрөлдөө ийн энэлсэнээр тэдгээр урьдын төрлүүдийн муу заяанд төрүүлэх буян бусын үйлийн үр нь ариусгагдах болмой. Бурханы бодийн хутгийг ч олох болой.

“Субути, би бээр илтэд мэдэн өгүүлвээс, өнгөрсөн тоо үгүй цагийн тэртээ, бас агуу их тоо үгүйн галавт, Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхан Дипанкарийн урьдын, бас их урьдын наян дөрвөн буман голди хийгээд наяд бурхад гарсаныг би бээр баясгаад, үл баясгахыг тэвчиснээс үл гомдоосон болой. Субути, тэдгээр Ялж Төгс Нөгцсөн Бурхадыг баясгаж үйлдсэнээс гомдоож эс үйлдсэн алин буй лугаа; хойдын цаг таван зууны эцэс болоход, энэ судрын аймгийг авах, бичих, барих, тогтоох, унших хийгээд бүхнийг агуулан үйлдэх алин буйг [харьцуулваас], Субути, эл буяны цогцод урьдын зууны буяны цогц хувь бээр ойр үл одмой. Мянгын хувь, бумын хувь, тоо, хэмжээ, тооцоолохуй, үлгэр, хань хийгээд шалтгааны [төдийд] ч үл хүлцэх болой.

“Субути, хэрвээ тэр цагийн тэдгээр язгууртаны хөвгүүн, язгууртаны охины буяны цогцыг би бээр өгүүлвээс, хамаг амьтан согтууран [машид] согтонги болох бөгөөд сэтгэл хямрах больюу.

“Бас Субути, номын энэ зүйл нь санаж сэтгэшгүй бөгөөд ач үрс нь ч бас санаж сэтгэшгүй чанарт болохыг мэдэгтүн!”

Тэндээс Амин гавъяат Субути бээр Ялж Төгс Нөгцсөнд ийн хэмээн өчвэй: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, бодьсадвын хөлгөнд үнэхээр орогсод бээр хэрхэн оршин үйлдмүй, хэрхэн бүтээн үйлдмүй, хэрхэн сэтгэл машид барьж үйлдмүй?”

Тийн хэмээн өчсөн лүгээ Ялж Төгс Нөгцсөн бээр Амин гавъяат Субутид ийн хэмээн зарлиг болвой: “Субути, үүнд бодьсадвын хөлгөнд үнэхээр орсон [нэгэн] бээр ийн хэмээн, “би бээр хамаг амьтны цогц үлдвэргүйг нирвааны төвд паринирваанд оруулсан бөгөөд, тэр мэт хэмжээгүй амьтныг паринирваанд оруулсан боловч, алин амьтан бас [хараахан]

паринирваанд орсонгүй болой” хэмээн сэтгэл үүсгэгтүн! Тэр юуны тул хэмээвээс, Субути, хэрвээ бодьсадва амьтанд хуран мэдэхүй орвоос түүнийг бодьсадва хэмээн үл нэрийдмүй. Бодгалын хүртэл хуран мэдэхүй орвоос ч бас түүнийг бодьсадва хэмээн үл нэрийдюү. Түүнийг бодьсадва хэмээн үл нэрийдэхийн тулд болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, “бодьсадвын хөлгөнд үнэхээр орсон” хэмээн нэрийдэхүйн ном тэр алин бээр үгүйн тулд болой.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэн бээр Түүнчлэн Ирсэн Дипанкараас алин дээр үгүйн үнэн төгс туулсан бодийн хутагт илтэд туулсан бурхан болсон ном аль буй хэмээн сэтгэмүй?”

Тийн хэмээн зарлиг болсон лугаа Амин гавъяат Субути бээр Ялж Төгс Нөгцсөнд ийн хэмээн өчвэй: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, Түүнчлэн Ирсэн бээр Түүнчлэн Ирсэн Дипанкараас алин дээр үгүйн үнэн төгс туулсан бодийн хутагт бурхан болсон тэр ном алин бээр үгүй болой.”

Тийн хэмээн өчсөн лүгээ Ялж Төгс Нөгцсөн бээр Амин гавъяат Субутид ийн хэмээн зарлиг болвой: “Субути, тэр түүнчлэн болой. Тэр түүнчлэн болой. Түүнчлэн Ирсэн бээр Түүнчлэн Ирсэн Дипанкараас алин дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт илтэд туулсан бурхан болсон тэр ном алин бээр үгүй болой. Субути, хэрвээ Түүнчлэн Ирсэн бээр алин илтэд туулсан бурхан болсон тэр номын зарим нэгэн зүйл буй болвоос Түүнчлэн Ирсэн Дипанкара бээр надад “бярманы⁴² хөвгүүн чи ирээдүйн цагт Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхан Шагжатүв хэмээгдэх болмой” хэмээн бивангирд эс үзүүлэх бөлгөө. Субути, энэ мэт Түүнчлэн Ирсэн бээр алин дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт илтэд туулсан бурхан болсон тэр ном алин бээр үгүйн тулд Түүнчлэн Ирсэн Дипанкара бээр надад “бярманы хөвгүүн чи ирээдүйн цагт Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Шагжатүв нэрт Бурхан хэмээгдэх болмой” хэмээн бивангирд үзүүлсэн болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, Түүнчлэн Ирсэн хэмээгдэх нь үнэхээрийн түүнчлэнхүү чанарын үсэг, нэр нэрийдсэн бүхийн тулд болой.

“Бас Субути, алин зарим нэгэн ийн хэмээн, “Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхан бээр дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт илтэд туулсан бурхан боллоо” хэмээх бөгөөс тэр буруу өгүүлэгч мөн болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, Түүнчлэн Ирсэн бээр алин дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт илтэд туулсан бурхан болсны тэр ном алин бээр үгүйн тулд болой. Субути, Түүнчлэн ирсэн бээр илтэд туулсан бурхан болсон ба, номлон үзүүлсэн алин тэр номд үнэн ч үгүй, худал ч үгүй болой. Тиймийн тул, Түүнчлэн Ирсэн бээр “хамаг ном бурханы ном” хэмээн номловой. Субути, хамаг ном хэмээгдэх нь тэдгээр хамаг ном үгүй бөгөөд тиймийн тул “хамаг ном бурханы ном”

хэмээгдьюү. Субути, энэ мэт бөгөөд үлгэрлэвээс, нэгэн хүмүүн төрөлхийтөн бие лүгээ төгөлдөр бөгөөд их биет болсон адил болой.”

Амин гавъяат Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, Түүнчлэн Ирсэн бээр “нэгэн хүмүүн төрөлхийтөн бие лүгээ төгөлдөр бөгөөд их биет” хэмээн алин тэр номлосныг Түүнчлэн Ирсэн бээр бие бус хэмээн номлосон болой. Тиймийн тул, “бие лүгээ төгөлдөр бөгөөд их биет” хэмээгдьюү.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, тэр түүнчлэн буюу. Тэр түүнчлэн буюу. Алин зарим Бодьсадва ийн хэмээн, “би бээр амьтан бүхнийг паринирваанд оруулав” хэмээх бөгөөс тэр бодьсадва хэмээгдэх бус болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, бодьсадва хэмээгдэхүйн тэр ном аль буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, тиймийн тул, Түүнчлэн Ирсэн бээр “хамаг ном нь амьтан үгүй, амин үгүй, бодгал үгүй” хэмээн номлосон билээ.

“Бас Субути, зарим нэгэн бодьсадва ийн хэмээн, “би бээр байгуулсан орон бүхнийг бүтээв” хэмээх бөгөөс тэр бээр түүнчлэн адилыг өгүүлсэн хэрэг болмуй. Тэр юуны тул хэмээвээс, Субути, “байгуулсан орон, байгуулсан орон” хэмээгдэх нь тэдгээр “байгуулсан орон үгүй” хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тул болой. Тиймийн тул, “байгуулсан орон” хэмээгдьюү. Субути, алин нэгэн бодьсадва ийн хэмээн, “хамаг ном нь би үгүй, хамаг ном нь би үгүй буюу” хэмээн дуршигч түүнийг Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхан бээр бодьсадва, махасадва хэмээн нэрийдьюү.

“Субути үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэнд махан нүд буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бөлгөө. Түүнчлэн Ирсэнд махан нүд буй болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэнд тэнгэрийн нүд буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бөлгөө. Түүнчлэн Ирсэнд тэнгэрийн нүд буй болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэнд билгийн нүд буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бөлгөө. Түүнчлэн Ирсэнд билгийн нүд буй болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэнд номын нүд буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бөлгөө. Түүнчлэн Ирсэнд номын нүд буй болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэнд бурханы нүд буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бөлгөө. Түүнчлэн Ирсэнд бурханы нүд буй болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Ганга мөрний элс хэдий чинээчлэн Ганга мөрөн ч бас төдий чинээ тоот болсон дор тэдгээрийн элс төдийчинээгийн ертөнцийн оронд хувирваас, тэдгээр ертөнцийн орон олон буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бөлгөө. Тэдгээр ертөнцийн орон олон болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, тэдгээр ертөнцийн орны амьтан хэдийчинээ буй тэдгээрийн санаж сэтгэх тус бүрийн сэтгэлийн үндсийг би бээр сайтар мэдмүй. Тэр юуны тул хэмээвээс, Субути, “сэтгэлийн үндэс, сэтгэлийн үндэс” хэмээгдэх тэр нь үндэс бус хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тул болой. Тиймийн тул, “сэтгэлийн үндэс” хэмээгдьюү. Тэр юуны тул хэмээвээс, Субути, урьдын сэтгэл ч зоригдошгүй, хойдын сэтгэл ч зоригдошгүй, эдүгээ цагт төрсөн сэтгэл ч зоригдошгүйн тулд болой.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Хэн бээр гурван мянган их мянган ертөнцийн энэ орныг элдэв долоон их эрдэнэсээр сайтар дүүргэж өглөг өгвөөс, тэдгээр язгууртаны хөвгүүн, язгууртаны охин тэр шүтээнээс их олон буян үүсгэх болмуй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, олон болой. Сайвар Одсон минь ээ, олон болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, тэр түүнчлэн буюу, тэр түүнчлэн буюу. Тэдгээр язгууртаны хөвгүүд, язгууртаны охид тэр шүтээнээс буяны цогц олныг үүсгэх бөлгөө. Бас Субути, хэрвээ буяны цогц, буяны цогцод болвоос, “буяны цогц, буяны цогц” хэмээн Түүнчлэн Ирсэн бээр үл номломуй.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Дүрсийн бие⁴³ огоот бүтсэнийг Түүнчлэн Ирсэнд үзэн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бус болой. Дүрсийн бие огоот бүтсэнийг Түүнчлэн Ирсэнд үл үзэх бөлгөө. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, “дүрсийн бие огоот бүтсэн” хэмээвээс, тэр огоот бүтсэн бус хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “дүрсийн бие огоот бүтсэн” хэмээгдьюү.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үзэж сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бус болой. Лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үл үзмүй. Тэр юуны тул хэмээвээс, Түүнчлэн ирсэн бээр лагшин бэлгэ хотол төгссөн алин [болохыг] номлосон болой. [Тэр нь] лагшин бэлгэ хотол төгссөн үгүй хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “лагшин бэлгэ хотол төгссөн” хэмээгдью.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэн бээр ийн хэмээн, “би бээр номыг номлон үзүүлсэн бөлгөө” хэмээн таална хэмээн сэтгэмүй? Субути, тэр тийн үл болгоох бөгөөд Түүнчлэн Ирсэний аль тэр номлон үзүүлсэн ном алин бээр үгүйн тулд болой. Субути, хэн нэгэн ийн хэмээн, “Түүнчлэн Ирсэн бээр ном үзүүлсэн бөлгөө” хэмээн өгүүлвээс, Субути, энэ мэт үгүй [хоосон] лугаа буруу барьсан тул намайг гүтгэсэн болмой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, номыг үзүүлсэн хэмээн, аливаа “ном үзүүлсэн, ном үзүүлсэн” хэмээгдэн зоригдох болсон тэр ном алин бээр үгүйн тулд болой.”

Тэндээс Амин гавъяат Субути бээр Ялж Төгс Нөгцсөнд ийн хэмээн өчвэй: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, хойдын цагт аль нэгэн амьтан энэ мэтийн ном хийгээд номлолыг сонсовч илтэд сэтгэл ихэд үл урвана хэмээн сэтгэмүй?”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, тэдгээр нь амьтан ч бус, амьтан бус нь ч бус болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, “амьтан” хэмээгдэх нь Түүнчлэн Ирсэн бээр тэдгээр амьтныг үгүй бээр номлосны тулд болой; тиймийн тул, “амьтан” хэмээгдью.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэн бээр алин дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт, илтэд туулсан бурхан болсон тэр ном аль буй хэмээн сэтгэмүй?”

Амин гавъяат Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, Түүнчлэн Ирсэн бээр алин дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутагт, илтэд туулсан бурхан болсон тэр ном алин бээр үгүй болой.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, тэр түүнчлэн бөлгөө. Тэр түүнчлэн бөлгөө. Түүнд ном өчүүхэн ч үл зоригдох бөгөөд үгүй болой; тиймийн тул, “дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутаг” хэмээгдью.

“Бас Субути, тэр ном (дээдийн ном) нь сацуу бөгөөд түүнд сацуу бус лугаа сацуу алин бээр үгүй (нэгэнт түүнд сацуу бус хэмээх зүйл нэг ч байдаггүй сацуу [чанарт] тул); тиймийн тул, “дээр үгүй үнэн төгс туулсан бодийн хутаг” хэмээгдью. Дээр үгүй үнэн төгс туулсан тэр бодийн хутаг нь би үгүй, амьтан үгүй, амин үгүй хийгээд бодгал үгүйд сацуу бөгөөд буяны ном хамаг бээр илтэд туулсан мөн болой. Субути, “буяны ном, буяны ном” хэмээгдэх нь тэдгээр ном үгүй хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосон болой; тиймийн тул, “буяны ном” хэмээгдью.

“Бас Субути, язгууртаны хөвгүүн, язгууртаны охин алин зарим бээр гурван мянган их мянган ертөнцийн орны уулсын хаан Сүмбэр хэдийчинээ буй төдий тоотоор элдэв долоон их эрдэнэсийн цогцыг илтэд хураан өглөг өгсөнөөс, хэн бээр энэхүү билиг барамидас адаглаад дөрвөн мөрт шүлгийн төдийхнийг тогтоож, бусдад үнэхээр үзүүлвээс, Субути, энэ буяны цогцод урьд өмнийн буяны цогц нь зуун хувьд ч ойртож үл тэсэхээс, уг шалтгаанд хүртэл ч үл тэсмүй.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Түүнчлэн Ирсэн бээр ийн хэмээн, “би бээр олон амьтныг тонилгон гэтэлгэвэй” хэмээн таална хэмээн сэтгэмүй? Субути, тийн бүү сэтгэгтүн! Тэр юуны тул хэмээвээс, Субути, Түүнчлэн Ирсэний алин [тэдгээр] тонилгон гэтэлгэсэн амьтан алин бээр үгүйн тулд болой. Субути, хэрвээ Түүнчлэн Ирсэн бээр амьтан алин зарим нэгнийг тонилгон гэтэлгэх болвоос, тэр ямагт Түүнчлэн Ирсэн бээр би хэмээхэд баримтлах (би-д шунан барих) болоод, амьтанд баримтлах (шунан барих), аминд баримтлах (аминд шунан хүлэгдэх) хийгээд бодгалд баримтлах (шунах) болой. Субути, би хэмээн баримтлахуй (би-д шунахуй) хэмээх нь баримтлах үгүйд (шунах бус зүйл хэмээн) Түүнчлэн Ирсэн бээр номлосон бөгөөтөл, түүнийг нялх бэртэгчингүүд баримтлах (шунах) болой. Субути, “нялх бэртэгчингүүд” хэмээх нь тэдгээр төрөлхтөн үгүй (төрөлхтөн бус) хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосон болой; тиймийн тул, “нялх бэртэгчингүүд” хэмээгдьюү.

“Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үзэх буюу хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бус болой. Лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үзэх буюу хэмээн үл сэтгэмүй.”

Ялж Төгс нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, тэр түүнчлэн бөлгөө. Тэр түүнчлэн бөлгөө. Лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үл үзэх бөлгөө. Субути, хэрвээ лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үзэх болвоос, Чакравартин⁴⁴ хаан ч бас Түүнчлэн Ирсэн болмуй за; тиймийн тул, лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үл сэтгэгтүн!

Тэндээс Амин Гавъяат Субути бээр Ялж Төгс Нөгцсөнд ийн хэмээн өчвэй: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, би бээр Ялж Төгс Нөгцсөний хэрхэн номлосон утгыг ухах мэт болвоос, лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үл үзэх бөлгөө.”

Тэндээс Ялж Төгс нөгцсөн бээр тэр үест эдгээр шүлгийг зарлиг болвой:

“Хэн бээр намайг дүрсэд үзэгч
Хэн бээр намайг дуунд мэдэгч
Харш буруу мөрд орсон мөн тул
Хамаг тэдгээр төрөлхтөн намайг үл үзьюү.

Хамаг бурхад нь номын чанар⁴⁵ бөгөөд
Хөтлөгч сартваахи⁴⁶ нар нь номын бие
Хамаг номын чанар мэдэгдэхүүн бус тул
Хэрхэвч түүнийг тийн мэдэж үл чадъяу.”⁴⁷

Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Лагшин бэлгэ хотол төгссөнөөр Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бодийн Хутагт Илтэд Туулсан Бурхан болмой хэмээн баримтлаваас, Субути, чи бээр тийн үл сэтгэгтүн! Субути, лагшин бэлгэ хотол төгссөнөөр Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бодийн Хутагт Илтэд Туулсан Бурхан болох үгүй болой.

“Субути, чи ийн хэмээн, “бодьсадвын хөлгөнд үнэхээр орогсод бээр алин зарим нэгэн ном тийн эвдэрсэн хийгээд тасарсанд нэрийдсэн [болой]” хэмээн баримталваас, Субути, тэр тийн үзэх хэрэг бус бөгөөд бодьсадвын хөлгөнд үнэхээр орогсод аль ч номыг тийн эвдэрсэн буюу тасарсанд нэрийдсэн үгүй болой.

“Бас Субути, язгууртаны хөвгүүн, язгууртаны охин хэн бээр Ганга мөрний элсний чинээ тоот ертөнцийн орныг элдэв долоон их эрдэнэсээр сайтар дүүргээд өглөг өгсөнөөс, бодьсадва хэн бээр номын энэ зүйлийг би үгүй бөгөөд төрөл үгүйд хүлцэнгүйг олвоос, тэр ямагт шүтээнээс асар их олон, тоо томшгүй бөгөөд цаглашгүй буяны цогц үүсэх болой. Бас Субути, бодьсадва бээр буяны цогцыг огоот барин эс үйлдмүй.”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, бодьсадва бээр буяны цогцыг огоот барин эс үйлдмүй хэмээн сэтгэмүй?”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, огоот барихын сацуу бээр бурууд үл барих бөгөөд; тиймийн тул, “огоот барих” хэмээгдью.

“Бас Субути, алин зарим нэгэн ийн хэмээн, “Түүнчлэн Ирсэн одов, ирэв, босов, суув эс бөгөөс унтаж болгоов” хэмээх бөгөөс, тэрбээр миний номлосон утгыг үл ойлгосон хэрэг болой. Тэр юуны тул хэмээвээс, Субути, Түүнчлэн Ирсэн хэмээгдэх нь хаашаа ч эс одох, хаанаас ч эс ирэхийн тулд болой; тиймийн тул, “Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Үнэн Төгс Туулсан Бурхан” хэмээгдью.

“Бас Субути, алин зарим нэгэн язгууртаны хөвгүүн, язгууртаны охин бээр гурван мянган их мянган ертөнцийн орон газрын шорооны тоос хэдийчинээ буй, энэ мэт бөгөөд үлгэрлэвээс, параманус⁴⁸ чуулсанчилан адил болвоос, Субути, үүнийг юун хэмээн сэтгэмүй? Параманусын тэр чуулган олон буй хэмээн сэтгэмүй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тэр тийм бөлгөө. Параманусын тэр чуулган олон болой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, хэрвээ

параманусын нэгэн чуулган байх бөгөөс, Ялж Төгс Нөгцсөн бээр “параманусын чуулган” хэмээн үл зарлиглахын тулд болой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн бээр “параманусын чуулган” хэмээн алин номлосон тэр чуулган үгүй хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “параманусын чуулган” хэмээгдьюү. Түүнчлэн Ирсэн бээр гурван мянган их мянган ертөнцийн орон хэмээн алин номлосон тэр нь орон бус хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосон болой; тиймийн тул, “гурван мянган их мянган ертөнцийн орон” хэмээгдьюү. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, хэрвээ ертөнцийн нэгэн орон буй болвоос, тэр ямагт бүгдэд баримтлах болохын тулд болой. Түүнчлэн Ирсэн бээр бүгдэд баримтлахуйд номлосон тэр нь баримтлах үгүй хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “бүхэнд баримтлахуй” хэмээгдьюү.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, бүгдэд баримтлахуй нь нэрийтгэл болой; тэр ном нь өгүүлшгүй мөн болой. Түүнийг нялхас бэртэгчингүүд л барих болой. Субути, алин зарим нэгэн ийн хэмээн, “Түүнчлэн Ирсэн бээр би хэмээн барих үзлийг номломуй, Түүнчлэн Ирсэн бээр амьтанд үзэх, аминд үзэх хийгээд бодгалд үзэхүйг номловой” хэмээн өгүүлвээс, тэрбээр ариун үнэн үгсээр өгүүлсэн болмуй?”

Субути бээр өчрүүн: “Ялж Төгс Нөгцсөн минь ээ, тийм бус болой. Сайвар Одсон минь ээ, тийм бус болой. Тэр юуны тул хэмээвээс, Ялж Төгс Нөгцсөн минь ээ, Түүнчлэн Ирсэний би хэмээн үзэхүйд алин номлосон түүнийг үзэл бус хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “би хэмээн үзэхүй” хэмээгдьюү.”

Ялж Төгс Нөгцсөн бээр зарлиг болруун: “Субути, үүнд бодьсадвын хөлгөнд үнэхээр орогсод энэ мэт хамаг номыг мэдэгдэхүүн, үзэгдэхүүн, дуршихуун бөгөөд номд нэн хуран мэдэхүйд эс оршин мэдэгтүн! Тэр юуны тул хэмээвээс, Субути, “номд хуран мэдэхүй, номд хуран мэдэхүй” хэмээгдэх нь тэр хуран мэдэхүй үгүй хэмээн Түүнчлэн Ирсэн бээр номлосны тулд болой; тиймийн тул, “номд хураан мэдэхүй, номд хураан мэдэхүй” хэмээгдьюү.

“Бас Субути, бодьсадва, махасадва хэн бээр ертөнцийн орон цаглашгүй бөгөөд тоо томшгүйг элдэв долоон их эрдэнэсээр сайтар дүүргээд өглөг өгсөнөөс, язгууртаны хөвгүүн, язгууртаны охин хэн бээр энэхүү билиг барамидеас адаглаад дөрвөн мөрт шүлгийн төдийг бичсэнээс барьсан, тогтоосон, уншсан, бүхнийг агуулан үйлдсэн, бусдад аугаа ихэд үнэхээр сайтар номлон үзүүлсэн тэр ямагт шүтээнээс асар их олон, тоо томшгүй, цаглашгүй буян үүсэх бөлгөө.

“Хэрхэн үнэхээр сайтар номлон үзүүлмүй хэмээвээс, хэрхэн үнэхээр сайтар номлон эс үзүүлэх, түүнчлэнхүү үнэхээр сайтар номлон үзүүлэгч бөгөөд; тиймийн тул, түүгээр “үнэхээр сайтар номлон үзүүлэгч” хэмээгдьюү.

Од эрхис, бүргэлзэхүй, зул хийгээд

Хоосон илбэ, шүүдэр, усны цөврүү ба
Оргүй зүүд, гилбэлгээн⁴⁹ хийгээд үүлэн мэт
Хамаг хуран үүдэгсдийг тэр мэт үзэгтүн!

Ялж Төгс Нөгцсөн бээр тийн хэмээн зарлиг болсонд бат агч⁵⁰ Субути хийгээд аяга тахимлиг тэдгээр ба, бодьсатва хийгээд дөрвөн нөхөд аяга тахимлиг, шимнанц⁵¹, увш ба увсанз⁵², тэнгэр, хүмүүн, асура хийгээд гандари⁵³ лугаа сэлтийн ертөнц дахин баясан бишрээд Ялж Төгс Нөгцсөний номлосныг илтэд сайшаан магтвай.

“Хутагт Билгийн Чиндад Хүрсэн Очироор Огтлогч” хэмээгдэх Их Хөлгөн Судар төгсвэй.

НАМО ВХАГАВАДЭ/ БРАЖНЯА БАРАМИДА ЕЭ/ УМ НАДДА ДИДА/ ИЛИШИ/ ИЛИШИ/
МИЛИШИ/ МИЛИШИ/ ВХИНА ЯН/ ВХИНА ЯН/ НАМО ВХАГАВАДЭ/ БРАДЯАМ БРАДИ/
ИРИДИ/ ИРИДИ/ МИРИДИ/ МИРИДИ/ ШҮРИДИ/ ШҮРИДИ/ ҮШҮРИ/ ҮШҮРИ/ ВХҮЮУ ЕЭ/
ВХҮЮУ ЕЭ СУХА.⁵⁴

“Очироор Огтлогч”-ийн энэ зүрхэн охийг нэгэнтээ урин уншсанаар “Очироор Огтлогч”-ийг есөн түмэн мянга уншсан лугаа сацуут болмой.

УМ ЕЭ ДХАРМА ХЭДҮ БРАВАХА ХЭДҮ НЭДЭ ХЁНДА ТАГАДО ЖАВА ДАД/
ДЭХЁНЯЗА ЁНИРОДХА ЭВАМ ВАДИ МАХА ШРАМАНА СУХА/ УМ БАЗАР САДУ САМАЯА/
МАНУ БАЛАЯА/ БАЗАР САДУ ДЭНОБА ДИШТА/ ДРИДХО МЭВХАВА/ СУДОХЁО МЭВХАВА/
СУБОХЁО МЭВХАВА/ АНУ РАГДО МЭВХАВА/ САРВА СИДДХИ МЭМЭ БРАЯАЗЦА/ САРВА
ГАРМА СУЗАМЭ ЗИДДАМ/ ШРИ ЯА/ ГҮРҮ ХУМ/ ХА ХА ХА ХА ХО/ ВХАГАВАНА САРВА
ДАТАГАДА БАЗАР МАМЭ МҮНЗА/ БАЗРИ ВХАВА/ МАХА САМАЯА САДУ АА ХУМ/ УМ
СУСИДИ.⁵⁵

Эл тус хэрэг бүхэн бүтээгдэхүйн тааллын шим огторгуйн төвөөс билиг барамидын ус баригч үүлс бүрхсэний хурын урсгал хувь сайт номхотгогдохууны орон газарт сайтар бууснаар гүн гүнзгий боловсруулан гэтэлгэхүйн ургац тариа яахин үл боловсрох билээ. Тэр мэтийн сайн номлолоор хувилгасан энэ ботийн шинээр үүсгэсэн буяны ургацаар ялгуусны шашин арвидан дэлгэрч, буруу мөрд тэнүүчлэн төөрсөн амьтан бүхэн зовлонгоос амсхийн сэргэхүйн дээдэд урвах болтугай. Ахуй үесийн үл хүсэх харш нөхцөл бүхэн амирлах бөгөөд үзүүр нэг дээдийн номыг бүтээхүйд хичээн шамдаж, ялгуусаны хөвгүүдийн явдлын их давалгааныг би бээр илтэд бүтээх болтугай.

...хэмээгдэх асар цагаанд урвуулах номын чанарыг унш!

Зүүлт тайлбар:

1. “Очироор огтлогч” (Санс.Vajracchedika) – Энэхүү сударт “Очир” буюу “vajra” хэмээх үгийн утгын талаар онцгойлон дурьдагдаагүй байна. Ерөнхийд нь судрыг “Билиг барамид” хэмээн нэрийдсэн байдаг: “Субути, энэ номын зүйлийн нэр нь “Билиг барамид” хэмээгдэх бөгөөд үүнийг тэр мэт тогтоогтүн!” хэмээжээ. Очир бол бурханы шашны очирт хөлгөний ёсны хөдөлбөргүй мөрийн гол билэгдэл мөн. “Важра” хэмээх санскрит нэр томъёо “бат бөх, хүчирхэг” гэсэн утга бүхий байхад түүний төвд хэлэн дэх орчуулга болох “дор-жэ” нь “чулууны” (дор) богд эзэн (жэ) хэмээх утгатай байдаг байна. Тэгэхээр энэ нь огтлогдошгүй бөгөөд эвдэгдэшгүй чулуу болох очир алмаз лугаа адил хатуу бат бөх бөгөөд гайхамшигт үзэсгэлэнт гэсэн утга юм. Бурханы шашинд “очир” нь бурханы хутгийг олсны их гэгээрэл буюу үнэмлэхүй үнэний нэвтэршгүй, арилгашгүй, хөдлөшгүй, хувиргашгүй, хуваагдашгүй бөгөөд эвдэгдэшгүй мөн чанарыг бэлгэддэг байна. Камалашилагийн тайлбарт (204а тал) “очир” хэмээхийг эвдэгдэшгүй зэвсэг, хэрэглэгдэхүүн гэсэн байдаг: “Энэ нь хоёр зүйл аргаар “очироор огтлогч” юм. Энэ бол тархааж эвдэхүйеэ бэрх очир мэт нисваанисын түйтгэр хийгээд мэдэгдэхүүний нарийн түйтгэрийг огтлогч мөн – энэ нь хоёр түйтгэрээс хагацахын хэрэг тусыг илтгэж буй юм. Энэчлэн огтлох нь гарцаагүй очирын хэлбэр дүр лүгээ ижил нэгэн мөн тул “очир лугаа” болой: Очирын төв хэсэг нь нарийн атал хоёр үзүүр нь булцуу адил дэлбэгэр байдаг юм. Энэ адилаар билгийн чиндад хүрсэн үүнийг анханд хийгээд адагт дэлгэрэнгүй айлдаж зарлигласан байдаг билээ – зоригдох үйлсийн орон хийгээд бурханы орон. Харин төв дундах нарийн хэсэг нь үлэмж зоригдолын хиргүй ариун орон болой. Тиймээс, чухамхүү очирын чанар лугаа адилаар энэ нь гурван орныг гол оногдохуун болгосны утга юм.” Үүнээс үзвэл “гол огтлогч” нь чинад хязгаараа хүрсэний билиг билгүүн, харин “огтлогдохуун” нь нисваанисын хийгээд мэдэгдэхүүний элдэв зүйл бүдүүн хийгээд нарийн түйтгэр мөн ажээ.
2. Ялж Төгс Нөгцсөн (Санс. Bhagavan) – Шагжамүни бурханы нэгэн илт өгүүлэх алдар бөгөөд зургаан эрдэм төгсөж, хоёр хязгаараас хагацан дөрвөн шуламыг дарсан тул ийнхүү нэрийджээ. Өөрөөр хэлвэл, хамаг номын

чанарыг төгс онож, хамаг нисваанис хийгээд мэдэгдэхүүний түйтгэрээс хагацсаны тул амьтанд барихгүй, аминд баримтлахгүй, бодгалд баримтлахгүй болсныг илэрхийлнэ. Учир нь тэрбээр хамаг хуран мэдэхүй лүгээ хагацсан нэгэн мөн болой.

3. Шраваста (Санс. shravasti) – Шагжамүни бурхан багшийн үеийн нэгэн хотын нэр.
4. Жэта (Санс. Jeta) – “Ялгуугч” хэмээх утга бүхий хүний нэр. Энд Ялгуугч хан хөвгүүний цэцэрлэг хэмээх нэрэмжит газрын нэрийн утгаар оржээ.
5. Анатапиндада (Санс. Anathapindada) – Итгэлгүй идээн өгөгч хэмээх утга бүхий нэр. Бурхан багшийн нэгэн гол өглөгийн эзэн байжээ.
6. Аягха тахимлиг- (Санс. Bhikshu. Тө. гэлэн)-шашны ёсны 253 зүйл сахил санваар сахигч хувраг хүн.
7. Бодьсадва-Хамаг амьтны тусын тулд төгс бодийн хутагт илтэд туулсан бурхан болохыг зоригдон их хөлгөний мөрийн эрдэм ухааныг бүтээгч бөлгөө. Бодьсавын үндсэн 18, гишүүн 46 сахилыг сахих бөгөөд туулан бүтээх 10 газар мөр бий. Эл сударт Ялж Төгс Нөгцсөн Бурхан бээр зарлиглахдаа: “бодьсавын хөлгөнд орсон бээр эх болсон хамаг амьтныг нэгээхэн ч хоцроолгүй нирвааны төвд (паринирваанд) оруулсугай. Тэр мэтээр цаглашгүй амьтныг паринирваанд оруулавч амьтан бүр хараахан бас паринирваанд орсонгүй [хэвээр] болой хэмээх сэтгэлийг үүсгэсэн, тэрчлэн амьтанд, аминд хийгээд бодгалд хураан мэдэхүй үл орж үйлдэх бөгөөд ер алин юунд ч үл баримтлан өглөг өгөгчийг бодьсадва” хэмээжээ.
8. Махасадва - Их төрөлхтөн
9. Бинваад идээ - өглөгийн идээ
10. Идээний үйлийг зохиох - үүнд олон зүйл үйл багтах бөгөөд бүгд хамаг амьтны тусыг бүтээхийн тухайд зоригдох үүднээс бүтээгдэх бөлгөө.
11. Цаг бусын идээ (санс. duta-gungah) – Бурхан багшийн номлосон идээний үйл лүгээ дияан бясалгалын үест тусгайлан баримтлах ёс. Тухайлбал, өдөрт нэг удаа хооллох.
12. Шударга завилах – нурууг сум мэт цэх шулуун агуулан завилж суухыг хэлнэ.
13. Амин гавъяат – Бурханы хүчээр насан төгөлдөр болсон буюу насны хутгийг олсон гэсэн үг. Өөрөөр хэлвэл, урт наст болсон гэсэн үг болно. Мөн зарим үед Бурханы шавь нарыг хүндэтгэсэн алдар болдог юм.
14. Субути (санс. Subhuti; Тө. Рав-жор) – “маш учрал” хэмээх утга бүхий бурханы нэгэн шавийн нэр.

15. Түүнчлэн Ирсэн (Tathagata) – бурханы илт өгүүлэх нэгэн нэр. Бурхан болохын мөр бүхэн ямар мэт, түүнчлэн ёсоор нь туулж ирсэн гэсэн утга болно. Эл сударт зарлиглахдаа: “Би хэмээхэд болоод амьтанд, аминд, бас бээр бодгалд баримтлах үзэлт болохын учирт Түүнчлэн Ирсэн нь “би бээр олон амьтныг тонилгон гэтэлгэвэй” хэмээн үл таалмой. Тэрчлэн Чакравартын хаан ч бас Түүнчлэн ирсэн болчих тул лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үл үзэх бөлгөө. Учир нь хамаг бурхад номын чанар бөгөөтөл тэрхүү номын чанар нь мэдэгдэхүүн бус юм. Тиймээс, Түүнчлэн Ирэгсэдийг дүрсэд үзэгч, дуунд мэдэгч тэдгээр нь эндүү ташимгай үзэлт мөн болой”.
16. Дайснаа дарсан (санс. Arhat) – хорт сэтгэл буюу нисваанисын дайсныг дарсан архадыг илт өгүүлэх нэр. Эл сударт Субути бээр өгүүлэхдээ: “хэрвээ Дайснаа Дарсан [архад], “би бээр Дайснаа Дарсан [архадын] хутгийг оллоо” хэмээн сэтгэвээс, тэр ямагт тэрээр би хэмээн баримтлах болмуй. Амьтанд баримтлах, аминд баримтлах хийгээд бодгалд баримтлах болмой. Үнэн Төгс Туулсан Бурхан бээр намайг нисваанис үгүй оршигсодын манлайн дээд хэмээн үзүүлсэн болой. Хэдийгээр би шунал тачаал лугаа хагацсан Дайснаа Дарсан Архад мөн боловч “би болвоос Дайснаа Дарсан болой” хэмээн үл сэтгэмүй. Учир нь хэрвээ би тэр мэт сэтгэх бөгөөс, Түүнчлэн Ирсэн бээр намайг “язгууртаны хөвгүүн Субути болвоос нисваанис үгүй оршигсодын манлайн дээд мөн бөгөөд юунд ч эс оршсон нь нисваанис үгүй оршсон” хэмээн бивангирд эс үзүүлэх болмуй” хэмээжээ.
17. Үнэн Төгс Туулсан – бурханы (илт өгүүлэх) нэгэн алдар нэр. Бурхан болох мөр бүхнийг үнэн төгс туулан бүтээсэн гэсэн үг.
18. Огоот – бүрэн төгс, бүрэн гүйцэд гэсэн үг.
19. Хатингадах – Ялж Төгс Нөгцсөн Бурхан тэдгээр бодьсадва, махасадва нарт туслахын дээдээр туслахын сацуу бас тэднийг хэзээ ямагт тольдон болгоож, эндүү ташимгайд нь нигүүлсэн түшиж, газар мөрийн ахиц бүхэнд нь таалан баясаж, ер нэгэн хормын төдийд ч орхилгүй хамт байдаг гэсэн үг.
20. Сайвар Одсон (санс. Sugata) – амгаланд ажирсан буюу одсон хэмээх утга бүхий бурханы (илт өгүүлэх) нэгэн алдар.
21. Үнэхээр - үнэн төгс, үнэн бодитой, бодит байдал болсон гэсэн утга.
22. Нирваан (санс. Nirvana) – “нир” хэмээх нь ерөнхийдөө үгүйсгэсэн, тухайлаад шахан гаргах гэсэн утга бүхий угтвар ахул “вана” хэмээх нь “агаар” гэх утга болно. Тэгэхээр энэ нь бүхэлдээ агаарыг шахан гаргах буюу амьсгал үл авах гэсэн утга

- болох юм. Бурханы сургаалийн ёсоор бол энэ нь “гаслангаас нөгцөхүй” гэсэн утга болно. Өөрөөр хэлвэл, зовлонгийн уг шалтгаан, орчлонгийн үйлийн үрийн хүлээснээс ангид тонилохуйн хутгийг олохуйн нэрийтгэл юм.
23. Паринирваан (санс. Parinirvana) – гаслангаас огоот нөгцсөн гэсэн утга. Нирвааны хутгийг бас бээр “нөхцөлөөс хараахан хагацаагүй” ба “нөхцөлөөс хагацсан” хэмээн хоёр ангилах бөгөөд “паринирваан” хэмээх нь гаслангийн нөхцөлөөс бүрэн төгс хагацсан гэсэн үг болно. Мөн бас нэгэн насандаа бурханы хутгийг олсон ихэс дээдсийг жанч халахад “паринирваан дүрийг үзүүлэв” гэдэг. Харин гагц Шагжамүни бурхан багшийн жанч халсан тухайд “махапаринирваан дүрийг үзүүлэв” хэмээн өгүүлдэг уламжлалтай.
24. Хуран мэдэхүй (санс. Samjna)-Аливаа амьтны мэдрэхүйн туршлалга хийгээд мэдэхүй хураагдан бүрэлдэх зэргэмж буюу түвшинийг тодорхойлох “таван цогц”-ын гурав дахь нь болой. Энэ нь аливаа юмсыг өөр хооронд нь ялгаварлан тангсан буюу хүртэхүйн түвшин юм.
25. Лагшин бэлгэ хотол төгссөн (санс. laksana-sampada) – гучин хоёр лагшин бэлгэ бүрэн төгс гэсэн үг.
26. Тэр ямагт-“тэр нь өөрөө”, “тэр шүтээнээс өөрөөс нь”, “зөвхөн тэр шүтээнээс л” гэхчилэн утга болно. Энд “шүтээн” гэдгийг суурь эс бөгөөс үндэс гэж болгооно уу.
27. Таван зууны эцэст-Эртний Энэтхэгийн Бурханы шашны уламжлалд Ялж Төгс Нөгцсөн (Шагжамүни) Бурханы шашныг “таван ‘таван зуун’ жил оршин дэлгэрнэ” хэмээх бөгөөд тэдгээрийн “төгсгөл цаг” бүр нь таван зүйл цөвийн улмаас шашин доройтно гэх тул түүнийг нэн онцгой цаг үест үздэг байжээ.
28. Сал онгоц-Хэрвээ номын энэ зүйлийг (билиг барамидыг) гаслангийн далайгаас туулан гэтэлгэх сал онгоц хэмээн мэдвээс гэсэн үг.
29. Язгууртаны хөвгүүн, язгууртаны охин-Бурханы сургаалийг суралцагч, залгамжлагч шавь нар гэсэн үг.
30. Гурван мянган их мянган ертөнц (Санс. Trisahasramahasahasram lokadhatu)- Бурханы шашны ном зохиолуудад өргөн дэлгэр хэрэглэдэг нэрийтгэл. Үндсэндээ, орон ертөнц нь дөрвөн тив, [найман дагуул тив], нар, сар, Сүмбэр (уулсын хаан), Хүсэлт тэнгэрийн орон хийгээд Эсэрүн тэнгэрийн анхдугаар дүрст орон зэргээс бүтдэг байна. Харин “гурван мянган ертөнц” гэдэг нь энэ адил орон ертөнцийн гурван ай зүйлийг нэрийддэг байна. Үүнд “бага мянган ертөнц” хэмээгдэх мянган ертөнц (мөнхүү тус тус дөрвөн тив бүхий); “дунд мянган ертөнц” хэмээгдэх мянган “бага мянган ертөнц” (1 сая ертөнц); “их мянган ертөнц” хэмээгдэх мянган “дунд

мянган ертөнц” (1 тэрбум). Тэгэхээр “гурван мянган их мянган ертөнц” гэдэг нь 100 живаа (голди) буюу 1000,000,000 (1 тэрбум) тоот ертөнц болой.

31. Нисваанис-“Хүлээс” хэмээх утга бүхий санскрит гаралтай үг. Амьтны мунхаг, уур хилэн хийгээд шунал тэргүүтэн элдэв зүйл хилэнцэт муу сэтгэлийг нэрийднэ. Ер нь нийт Энэтхэгийн шашин, соёл хийгээд гүн ухаанд “хүлээс ба гэтлэхүй” хэмээх нь нийтлэг ерөнхий ойлголт байдаг юм. Улмаар гаслан зовлонд хүлэгдэхийн уг ёзоор нь мунхаг тул түүнийг мэдлэг ухааны гэрлээр гийгүүлж гэтлэхүй хийгээд гэгээрлийн хутгийг олно гэдэг тухайд ч мөн л нийтлэг ерөнхий сургаал бүхий байдаг болно. Гэхдээ бурханы шашнаас бусад шашин хийгээд гүн ухааны тогтсон тааллуудад эл сударт айлдсан адил би хэмээн үл баримтлах, амьтан хэмээн үл баримтлах, амин хэмээн үл баримтлах, бодгал хэмээн үл баримтлах ёс байддаггүй юм. Тиймээс, тэд хүлээс хийгээд гэтлэхүйг хоосон чанар лугаа барилдуулж эс үзнэ.
32. Бивангирд-эш үзүүлэх гэсэн үг.
33. Дипанкара-(Санс. Dipankara)- Тоолшгүй олон галавын өмнө заларсан Бурханы нэр. Монгол ном зохиолуудад Дивангар хэмээдэг.
34. Билиг барамид (Санс. prajnapramita) - “пражня” нь “билиг”, “прамита” хэмээх нь “төгс дээд болох”, “төгөлдөржих” гэсэн утгатай - билгийн чинад хязгаараа хүрсэн гэсэн үг. Тэгэхээр элдэв зүйл хилэнц нисваанис хийгээд тэдгээрийн ёзоорыг огтлон таслагч хурц мэсэн бол чухамдаа хамаг номын чанарыг танин барьсан билиг билгүүн мөн тул тэр адилаар төгс бүтээх ном сургаал болно. Нийт 108 боть бүхий Монгол “Ганжуур”-ын 21 боть нь билиг барамидын ном байдаг. Харин Монгол “Данжуур”-ын 88, 89-с 105 боть хүртэл билиг барамидын аймгийн ном байдаг юм. Ерөнхийдөө, билиг барамидын дэлгэрэнгүй, дунд хийгээд хураангуй хэмээх гурван үндсэн зүйл ном бий. Энэхүү “Очироор Огтлогч” хэмээгдэх нь хураангуй зохиол болно.
35. Калинга (Санс. Kalinga)-эртний Энэтхэгийн нэгэн улсын нэр. Монгол ном зохиолуудад Галинга хаан хэмээдэг. Үүнийг зарим нэгэн барууны эрдэмтэд “kalirajah” буюу “буг чөтгөрийн хаан” хэмээн тайлсан байдаг боловч Төвд эхүүд болон Конзегийн санскрит эх тэргүүтэнд “калинга” хэмээн маш тодорхой бичсэн байдаг юм.
36. Үнэхээр номлосон-голт зүрхний угаас номлосон гэсэн үг.
37. Үнэнээр номлосон-үнэн номыг үзүүлсэн гэсэн үг.
38. Голди (Тө. Жива)-10 сая хэмээх тооны нэр.
39. Наяд-12 оронтой тоо буюу 100 тэрбум хэмээх тооны нэр.
40. Галав-өгүүлшгүй урт удаан хугацааг үлэх хэмжээ.

41. Бүхнийг агуулан үйлдэх-бүхнийг сайтар ойлгох гэсэн утга.
42. Бярман (Санс. Brahman)-эртний Энэтхэгийн нийгмийн тогтолцоог бүрэлдүүлэгч дөрвөн зүйл кастын хамгийн дээд кастын нэр.
43. Дүрсийн бие (Санс. purakaya)-Бурханы лагшин буюу биеийг хоёр ангилах бөгөөд тэдгээр нь номын хийгээд дүрсийн хэмээгдэх бөлгөө. Дүрсийн биеийг мөн хувилгааны хийгээд төгс жаргалангийн хэмээн хоёр ангилна.
44. Чакравартин (Санс. Sakravartini)-хүрдэн эргүүлэгч буюу орчиулагч хаан гэсэн үг. Монгол ном зохиолуудад Загарвардын хаан хэмээсэн байдаг. Энэ мэт хааныг төрөхийн өмнө билэгдэл тэмдэг нь агаарт тодордог гэх бөгөөд тэрбээр өөрөө лагшин бэлгэ хотол төгссөн байдаг байна.
45. Номын чанар (Санс. dharmata)-энэ нь хамаг ном буюу юмсын мөн чанар гэсэн утга болно. Энд хамаг юмсын янагуух мөн чанар болон тэдгээрийн тухай элдэв зүйл үзэлтийг бус харин чанагуух мөн чанарыг нэрийдэж буй юм. Эл сударт хамаг хуран үүдсэн номыг буюу юмсыг од, бүргэлзэхүй, зул, илбэ, шүүдэр, усны цөврүү, зүүд, гилбэлгээн хийгээд үүл мэт барин баримтлах зүйлгүй, өөрийн уг мөн чанараараа үнэхээр бүтсэн бус хоосон чанарт болохыг зарлиглажээ.
46. Сартваахи-Хөлөг онгоцны ахмад гэсэн утгатай үг. Энд их жолоодогч, хөтлөгч, удирдагч багш гэсэн утгаар ойлгоно.
47. Шүлгийн эхний шадад "...намайг үл үзьюү" хэмээсний учир нь бурхадын номын лагшныг номын чанараар буюу чанагуух мөн чанараар үзэхүйн тулд болой. Тэрчлэн хөтлөгч сартваахи, бурхадын лагшин номын бие бөгөөд чанагуух үнэн мөнийн тулд түүнийг алин нэгнээ баримталсан хураан мэдэхүй (сэрэл хүртэхүй) төдийхнөөр ямарваа нэг мэдэгдэхүүн буюу орон (объект) мэтээр мэдэх аргагүй юм. Тиймээс, эл сударт би хэмээх, амьтан хэмээх, амин хэмээх, бодгал хэмээхэд хуран мэдэл эс үүсгэх тухайд олонтаа айлдсан байдаг.
48. Параманус (Санс. Paramanus)-маш нарийн тоос гэсэн үг. "пара" гэдэг нь "олон"; "ану" гэдэг нь цаашид үл хуваагдах өчүүхэн жижиг хэсэг буюу тоос гэсэн үг. Энэ адил маш нарийн тоос нь шороо, ус, гал хийгээд хийн хэмээх дөрвөн махбод тус бүрийн байх тул ийнхүү "пара" буюу олон хэмээн үзэж, басхүү олон тоог илэрхийлэх "с" дагаварыг хэрэглэдэг байна. Харин Монгол ном судруудад "бараманус" хэмээн заншжээ.
49. Гилбэлгээн-цахилгаан гэсэн үг.
50. Бат агч (Санс. Sthavira; Тө. Най-дан)-санскрит нэрийг үгчлэн буулгавал эртний, ахмадын гэсэн утга болой. Энэ нь үндсэндээ эртний Буддизм буюу бага хөлгөний

ёстонуудыг ерөнхийлөн нэрийддэг нэр юм. Үүнийг “архад” хэмээхийн бас нэгэн зүйл нэр хэмээн үзэж болно.

51. Шимнанц (Санс. Bhikshuni; Тө. гэлэнмаа)-эх аягха тахимлиг гэсэн үг.
52. Увш ба увсанз (Санс. Uvasaka; uvasika; Тө. Гэнэн; гэнэнмаа)- Бурханы шашны эглийн буюу гэргийтний таван зүйл сахилыг сахигч эр хүмүүнийг увш, харин эмийг нь увсанз хэмээн нэрийддэг.
53. Гандари (Санс. Gandharvas)-нэгэн зүйл үнэр идэштэн амьтан. Бас түүнийг тэнгэрийн дууч ч гэж нэрийдэх нь бий.
54. Ялж Төгс Нөгцсөн Эх Билгийн Чиндад Хүрсэн дор мөргөмүй /Namo bhagavate prajnaparamitaye/. УМ /Om/ – Бурханы ариун лагшин, зарлиг хийгээд таалал. ...надда дида илиши илиши милиши милиши вхина ян вхина ян /natada tita ilishi ilishi milishi milishi bhimayana bhimayana/ – зэрэг нь үг болон нэрийтгэлийн ямарваа утгагүй. Харин ханьцашгүй тарнисын ёсны амьсгал хувиарлах, хүрд гүйлгэх эс бөгөөс сэтгэлийн үндэс тэргүүтэнд нөлөөлөх гэхчилэн утга бүхий бололтой. Эх Ялж Төгс Нөгцсөн дор мөргөмүй /Namo bhagavati/. ...ириди ириди мириди мириди шүриди шүриди үшүри үшүри вхүюү еэ вхүюү еэ /iriti iriti miriti miriti shuriti shuriti ushuri ushure bhuyuye bhuyuye/ – мөн үг болон нэрийтгэлийн утгагүй – бат оршиохын /svaha - суха/ тухайд тахимой /pradatyam prati/. **НАМО ВХАГАВАДЭ/ БРАЖНЯА БАРАМИДА ЕЭ/ УМ НАДДА ДИДА/ ИЛИШИ/ ИЛИШИ/ МИЛИШИ/ МИЛИШИ/ ВХИНА ЯН/ ВХИНА ЯН/ НАМО ВХАГАВАДЭ/ БРАДЯАМ БРАДИ/ ИРИДИ/ ИРИДИ/ МИРИДИ/ МИРИДИ/ ШҮРИДИ/ ШҮРИДИ/ ҮШҮРИ/ ҮШҮРИ/ ВХҮЮҮ ЕЭ/ ВХҮЮҮ ЕЭ СУХА**
55. Номын төгсгөлд: “номын учир шалтгаан болсон Бурханы ариун лагшин, зарлиг хийгээд таалалын учир шалтгааныг Түүнчлэн Ирэгсэд бээр үзүүлсэн бөгөөд тэдний гаслангаас огоот нөгцсөн нь ч түүнчлэн анхны “маха шрамана” буюу анхны их тойнд дулдуйдсан болой” /Om ye dharma hetu prabhava hetum tesam tathagatobhyah datta tesam sa yo nirodha evam adi maha sramana svaha/ хэмээгээд Базарсадын ариуслын зуун үсэгт тарниар дээдийн номыг илүүдүүлсэн хийгээд дутуудуулсан, үе гишүүнийг нь доройтуулсан зэрэг алин буй бүхнийг наминчлан ариусгасан болно. Эл тарнийн утга нь:
- УМ – Бурханы ариун лагшин, зарлиг хийгээд таалалын өлзийт сайн бөгөөд эрхэм дээдийн эрдэм увдис.
- БАЗАР САДУ – Их амгалан хийгээд хоосон чанарын хоёргүй билиг билгүүнт төрөлхтөн (бурхан).
- САМАЯА - Үл эвдэх андгай тангараг.

МАНУ БАЛАЯА - Өчүүхэн намайг бодь мөрд хөтлөн дагуулж соёрх оо.

БАЗАР САДУ ДЭНОБА ДИШТА - Өчүүхэн намайг Базарсадын ариун очирын таалалд ойр агуулан соёрх оо.

ДРИДО МЭВХАВА – Хамаг номын чанагуух мөн чанарыг хөдөлбөргүй бөгөөд бат ухааран оноход адистидлан соёрх оо.

СУДОХЁО МЭ ВХАВА – [Хамаг бурхад хийгээд их төрөлхийтнүүд] намайг хэзээ ямагт таалан баясаж байхын адистидийг хайрла аа.

СУБОХЁО МЭ ВХАВА – Машид боловсорсон их амгалант мөн чанараар адистидлан соёрх оо.

АНУРАГДО МЭ ВХАВА – Асрахуй таалалын мөн чанараар адистидлан эл хутагт хөтлөн дагуулж соёрх оо.

САРВА СИДДХИ МЭ БРАЯАЗЦА – Хамаг дээд эрдэм увдисыг (хутгийг) хайрлан соёрх оо.

САРВА ГАРМА СУЦАМЭ – Хамаг ялгуусны зохиол үйлсэд адистидлан соёрх оо.

ЗИДДАМ ШРИ ЯМ ГҮРҮ - Цогт төгс эрдэм увдис бүхнээ хайрлан соёрхно уу.

ХУМ – Ариун Очирын таалал

ХА ХА ХА ХА ХО – Таван чанагуух билиг билгүүн.

БХАГАВАН – Ялж Төгс Нөгцсөн Бурхан

САРВА ТАТАГАТА БАЗАР – Хамаг Түүнчилэн Ирсэн Очирын таалалтанууд – хоосон чанарыг илтэд оносон нугууд.

МЭМЭ МУНЗА – намайг хэзээ ямагт дагуулан соёрх оо (бүү орхиоч).

БАЗАР ВХАВА – Бат бөх очирын мөн чанараар орших.

МАХА САМАЯА САДУ – Их андгай тангарагт очир таалалтан.

АА – Ариун Очирын зарлиг.

ХУМ – Их амгалангийн чанагуух билиг билгүүн.

ПАД – Хоёргүй их амгалан хийгээд хоосон чанарын чанагуух билиг билгүүнийг тодорхой бүтээж үүнд түйтгэрлэх элдэв сэжигийг (хоёр сэтгэлийг) машид дарах.

**УМ ЕЭ ДХАРМА ХЭДҮ БРАВАХА ХЭДҮ НЭДЭ ХЁНДА ТАГАДО ЖАВА ДАД/
ДЭХЁНЯЗА ЁНИРОДХА ЭВАМ ВАДИ МАХА ШРАМАНА СУХА/ УМ БАЗАР САДУ САМАЯА/
МАНУ БАЛАЯА/ БАЗАР САДУ ДЭНОБА ДИШТА/ ДРИДХО МЭВХАВА/ СУДОХЁО
МЭВХАВА/ СУБОХЁО МЭВХАВА/ АНУ РАГДО МЭВХАВА/ САРВА СИДДХИ МЭМЭ
БРАЯАЗЦА/ САРВА ГАРМА СУЗАМЭ ЗИДДАМ/ ШРИ ЯА/ ГҮРҮ ХУМ/ ХА ХА ХА ХА ХО/
ВХАГАВАНА САРВА ДАТАГАДА БАЗАР МЭМЭ МУНЗА/ БАЗРИ ВХАВА/ МАХА САМАЯА
САДУ АА ХУМ/ УМ СУСИДИ.**

Жич: Энэ судрыг орчуулахдаа бид олон зүйл нэрийг хуучин монгол орчуулгын уламжлалыг баримтлан санскритаар, тэгэхдээ чухамхүү санскрит дуудлагаар нь оруулав. Бас зарим зүйл судрын үг хэллэгийг уншигч олонд ойлгомжтой болгох үүднээс ард нь хаалтанд орчин цагийн утга ойролцоо үгсээр илэрхийлэн оруулсан болно. Тиймээс та бүхэн тэдгээрийг зөвхөн ойролцоо утга илэрхийлэх төдий, чухамхүү үнэн зөв утгыг багшаар хөтлүүлэн ухаарах ёстой болохыг дурьдан уншиж болгооно уу!

Түвд хэлнээс орчуулсан Ч.Хатанбаатар

Хянан тохиолдуулсан Т.Булган